



**ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 1/07

Зуунмод сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Байгаль орчин, аялал жуучлалын газрын мод үржүүлгийн газарт төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

А.Зоригтоо	(Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны албаны дарга
------------	--

Гишүүд:

Ц.Нямгарав	(Аймгийн Барилга захиалагч, орон сууцны Корпораци ОНӨААТҮГазрын инженер)
А.Батзаяа	(Аймгийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны мэргэжилтэн)
Д.Дашдаваа	(Иргэний төлөөлөл), (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа	(Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжилтэн)
------------	--

2. Байгаль орчин, аялал жуучлалын газрын мод үржүүлгийн газарт тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (А.Зоригтоо)-д, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригтоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР



4152010325  
My doc. Zahiramj 202271 uliral